ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/554

танай ____________-ны № ______________-т

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ЧИНБАТ ТАНАА

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу төсвийн шууд захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "*Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ*" гэж заасны дагуу Үндэсний аудитын газарт ирүүлж, биелэлтийг ханган ажиллахыг зөвлөж байна.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хугацаанд нь биелүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "*Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно*", 42.2-т "*Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно*" гэж тус тус заасныг анхаарч ажиллана уу.

Хавсралт 26 хуудастай.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\0229 SNAG-8 Docx

0001050955

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/332

танай ____________-ны № ____________-т

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ЧИНБАТ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа босго үнийг баримтлалгүй 126,250.0 мянган төгрөгийн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авах гэрээ байгуулж, худалдан авсан;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 95,289.2 мянган төгрөгийн удирдах ажилтны хурал, зөвлөгөөн зохион байгуулж, хэрэгцээгүй бараа материал нөөцөлсөн;
- Бараа материалын 97,098.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг бүртгэлд тусгаж, тайлагнаагүй;
- Батлагдсан төсвөөс 111,244.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй 165,190.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан;

- Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, 85,020.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан

зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг 4.1.3, 4.1.6, 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.6, 15.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах" заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ" баримт бичгийн дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангаас 345,246.1 мянган төгрөг, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 51,750.3 мянган төгрөг нийт 396,996.4 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Агентлагийн батлагдсан бүтэц, орон тоонд багтаагүй Сургалт, судалгаа мэдээллийн төв нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/164 дүгээр тушаалын хүрээнд шинээр байгуулсан бие даасан төрийн үйлчилгээний төсвийн байгууллага боловч дээд шатны захирагчаас төсвийн шууд захирагчийн төсвийн хуваарийг тусад нь батлаагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 4 хөтөлбөр, 6 зорилт, 56 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас гүйцэтгэлээр 21 арга хэмжээг 70.0 хувь, 26 арга хэмжээг 50.0 хувь, 9 арга хэмжээг 30.0 хувь буюу нийт дүнгээр 56.0 хувиар үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 9006105
9823329..

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 299/А0171139 Улаанбаатар хот
СНАГ-2024/175/НА-СТ/А-ТМ213

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангаагүй 94,471,200.00 /ерэн дөрвөн сая дөрвөн зуун далан нэгэн мянга хоёр зуун/ төгрөг, онгоцны тийз, ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүй 70,716,700.00 /далан сая долоон зуун арван зургаан мянга долоон зуун/ төгрөг, нийт 165,190,800.00 /нэг зуун жаран таван сая нэг зуун ерэн мянга найман зуун/ төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"*, 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т *"нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Одонтунгалаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ
АУДИТОР Б.АРИУНЖАРГАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 257/А0171139 Улаанбаатар хот
СНАГ-2024/95/ЯА-СТА-ЛПШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын нийт 49 албан хаагчаас 41 албан хаагчид 82 удаа 16,954,587.61 /арван зургаан сая есөн зуун тавин дөрвөн мянган таван зуун наян долоон/ төгрөгийн цалинтай чөлөө олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх"*, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"* 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг 4.1.3-т *"үр ашигтай байх"*, 4.1.6-д *"сахилга баттай байх"*, 4.1.9-д *"хариуцлагатай байх"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т *"цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын албан хаагчдад нийтлэг цалинтай чөлөө олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Одонтунгалаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ
АУДИТОР Б.АРИУНЖАРГАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 258/А0171139 Улаанбаатар хот
СНАГ-2024/75/НА-СТА-ТШ43

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдын 2023 оны 3, 4 дүгээр улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшууллыг олгохдоо сарын үндсэн цалингийн 100.0 хувиар тооцон 14 албан хаагчид 18,883,640.00 /арван найман сая найман зуун наян гурван мянга зургаан зуун дөчин/ төгрөг, сахилгын шийтгэлтэй ажилтанд 496,679.40 /дөрвөн зуун ерэн зургаан мянга зургаан зуун далан ес/ төгрөг, нийт 19,380,319.40 /арван есөн сая гурван зуун наян мянга гурван зуун арван есөн/ төгрөгийн шагнал урамшууллыг олгож, 988,940.00 /есөн зуун наян найман мянга есөн зуун дөчин/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"*, 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, 16.5.7-д *"байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна."* Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан *Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7.Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.*Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын *3.1-д "Сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно."* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т *"цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 259/А0171139 Улаанбаатар хот
СНАГ-2024/75/НА-СПА-ПШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын /хуучин нэрээр/ 2023 оны А/192 дугаар тушаалаар хүслийн хайрцаг, дугтуй хэвлүүлэхэд 30,000,000.00 /гучин сая/ төгрөг, сургалт арга хэмжээний лед дэлгэцийн угсралтад 23,000,000.00 /хорин гурван сая/ мянган төгрөг, зураглал зохиох санхүүжилтэд 24,050,000.00 /хорин дөрвөн сая тавин мянган/ мянган төгрөг, мөн мэдээлэл сурталчилгаанд 49,200,000.00 /дөчин есөн сая хоёр зуун мянган/ төгрөг, нийт 126,250,000.00 /нэг зуун хорин зургаан сая хоёр зуун тавин мянган/ төгрөгийн нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээнд шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"*, 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"* ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.4-д *"Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно."*, 8.5-д *"Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно."*, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2023 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/20 дугаар тушаалын 1 дэх хэсэгт "Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хийх ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ байгуулах, үр дүнг дүгнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-т *"байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Одонтунгалаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ
АУДИТОР Б.АРИУНЖАРГАЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 260/А0171139 Улаанбаатар хот

СНАГ-2024/75/НА-СТА-ПЛУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын /хуучин нэрээр/ 2023 оны А/84 дүгээр тушаалаар хүүхдийн зуслангийн удирдлагуудыг чадавхжуулах сургалтад 18,095,000.00 /арван найман сая ерэн таван мянган/ төгрөг, А/123 дугаар тушаалаар ажлын байрны стресс менежментийн дотоод сургалтад 6,288,000.00 /зургаан сая хоёр зуун наян найман мянган/ төгрөг, нийт 24,383,300.00 /хорин дөрвөн сая гурван зуун наян гурван мянга гурван зуун/ төгрөгийг зарцуулж, үр ашиггүй, тэвчиж болох зардал зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"* 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д *"сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д *"төсвийг зориулалт бусаар зарцуулсан;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Одонтунгалаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АХЛАХ АУДИТОР | Д.БОЛОР-ЭРДЭНЭ |
| АУДИТОР | Б.АРИУНЖАРГАЛ |

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 261/А0171139 Улаанбаатар хот

СНАГ-2024/75/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж сургалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ зохион байгуулахад нийт 62,439,400.00 /жаран хоёр сая дөрвөн зуун гучин ес/ мянган төгрөгийн томилолтын зардал зарцуулсан, ажлын тайлан, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"* 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д *"сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д *"төсвийг зориулалт бусаар зарцуулсан;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Одонтунгалаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ
АУДИТОР Б.АРИУНЖАРГАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

1. Албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг тооцохдоо тогтоосон хувь хэмжээг баримтлалгүй, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Одонтунгалаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ
АУДИТОР Б.АРИУНЖАРГАЛ

АТА9693 9006109
9023030583

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 262/А0171139 Улаанбаатар хот
САНАГ-2024/75/НА-СПА-ПШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Агентлагийн орон тооны дээд хязгаарт багтаагүй байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт батлагдаагүй даргын туслах, тооцооны нягтлан бодогч, касс, эд аж ахуйн нярав, жолооч, үйлчлэгч зэрэг орон тоонд 7 албан хаагчийг гэрээгээр ажиллуулж 85,020,600.00 /наян таван сая хорин мянга зургаан зуун/ төгрөгийн цалин, Нийгмийн Даатгалын Шимтгэлийн зардалд зарцуулж байгаа талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т *"батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"*, 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т *"Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т *"аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, Засгийн газрын тогтоолоор баталсан бүтэц, орон хязгаарыг мөрдөж, зөрчлийг арилгах, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Одонтунгалаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АХЛАХ АУДИТОР | Д.БОЛОР-ЭРДЭНЭ |
| АУДИТОР | Б.АРИУНЖАРГАЛ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 263/А0171139 Улаанбаатар хот
САЛТ-2024/75/ХА-СТА-ЛГШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан тайлан ирүүлэх цаглаварт хугацаанаас 6 хоног хоцроож тайлан ирүүлсэн, аудит хийх явцад саад учруулан аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудалд хариу тайлбар хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т *"төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;"*, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т *"шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчаас тайлбар гаргуулах, тодорхой асуулт тавьж, хариулт авах;"*, 16 дугаар зүйлийн 16.1.3-т *"төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх;"* гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2-т *"Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ."* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Чинбат/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АХЛАХ АУДИТОР | Д.БОЛОР-ЭРДЭНЭ |
| АУДИТОР | Б.АРИУНЖАРГАЛ |

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........................................................ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........................ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................ 6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................ 8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........................................ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........................................ 13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........................................ 14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........................................ 14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........................................ 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................ 16
3.5.1 Төсвийн төлөвлөлт ........................................ 16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ........................................ 16
3.5.3 Нэмэлт төсөв ........................................ 17
4. АУДИТЫН ТАЙЛАН ........................................ 18
4.1 Ерөнхий зүйл ........................................ 18
4.2 Материаллаг байдал ........................................ 18
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 18
4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........................................ 18
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................ 19
4.4.1 Завсрын аудитын талаар ........................................ 19
4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ................ 19
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................ 19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........................................ 20
5.1 Албан шаардлага ........................................ 20
5.2 Зөвлөмж ........................................ 22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........................ 26

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| ГБХЗХГ | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| ССМТ | Сургалт, судалгаа, мэдээллийн төв |
| СНАГ | Санхүү-Нийцлийн аудитын газар |
| ТНБД | Төрийн нарийн бичгийн дарга |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ҮОМШ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал |
| ХГБХХЕГ | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/332

танай ______ -ны № ______ -т

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ЧИНБАТ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа босго үнийг баримтлалгүй 126,250.0 мянган төгрөгийн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авах гэрээ байгуулж, худалдан авсан;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 95,289.2 мянган төгрөгийн удирдах ажилтны хурал, зөвлөгөөн зохион байгуулж, хэрэгцээгүй бараа материал нөөцөлсөн;
- Бараа материалын 97,098.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг бүртгэлд тусгаж, тайлагнаагүй;
- Батлагдсан төсвөөс 111,244.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй 165,190.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан;

- Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, 85,020.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан

зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг 4.1.3, 4.1.6, 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.6, 15.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах" заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг 463,731.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь хүүхэд харах үйлчилгээний арга хэмжээг 205,771.3 мянган төгрөг, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний арга хэмжээг 216,454.6 мянган төгрөг, нийгмийн бүлэгт чиглэсэн арга хэмжээг 71,095.9 мянган, урьдчилан сэргийлэх арга хэмжээг 23,092.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| | | **Нийт дүн** | **5,261,580.5** | **4,797,849.2** | **463,731.3** | **91.2** |
| **1** | **72207** | **Хүүхдийн хөгжил хамгаалал** | **4,752,639.2** | **4,580,013.7** | **172,625.5** | **96.4** |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагаа | 1,142,927.5 | 1,377,008.2 | (234,080.7) | 120.5 |
| 1.2 | 80205 | Мэдээлэл сурталчилгаа | 50,000.0 | 48,400.0 | 1,600.0 | 96.8 |
| 1.3 | 80231 | Хүүхэд харах үйлчилгээ | 2,140,303.4 | 1,934,532.1 | 205,771.3 | 90.4 |
| 1.4 | 80237 | Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ | 927,408.5 | 710,953.9 | 216,454.6 | 76.7 |
| 1.5 | 80238 | Урьдчилан сэргийлэх арга хэмжээ | 451,014.8 | 427,922.5 | 23,092.3 | 94.9 |
| 1.6 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 40,985.0 | 31,599.9 | 9,385.1 | 77.1 |
| **2** | **72203** | **Хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх** | **190,985.5** | **68,205.4** | **122,780.1** | **35.7** |
| 2.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагаа | 190,856.9 | 68,105.4 | 122,751.5 | 35.7 |
| 2.2 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 128.6 | 100.0 | 28.6 | 77.8 |
| **3** | **72209** | **Залуучууд болон оюутнууд** | **139,605.8** | **68,509.9** | **71,095.9** | **49.1** |
| 3.1 | 83115 | Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ | 139,605.8 | 68,509.9 | 71,095.9 | 49.1 |
| **4** | **72212** | **Гэр бүлийн хөгжил хамгаалал** | **178,350.0** | **130,717.1** | **47,632.9** | **73.3** |
| 4.1 | 83115 | Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ | 178,350.0 | 130,717.1 | 47,632.9 | 73.3 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/165, 189 дүгээр тушаалаар тэгш боломжийн төлөө залуучуудын манлайллын сургалтын санхүүжилт 86,500.0 мянган төгрөг, НҮБ-ийн Хүүхдийн сан, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилт 345,246.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 34,574.1 мянган төгрөг, нийт 466,320.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 435,496.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 27,298.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 3,525.0 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах болон бараа материалын бүртгэл, үндсэн хөрөнгө, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитор Б.Ариунжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 01/82 дугаар албан бичгээр Төсвийн тухай хуульд заасан тайлан ирүүлэх цаглабарт хугацаанаас 6 хоног хоцроож ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,654,337.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 66,543.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 171 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-д "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллах, зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.4.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад ХГБХХЕГ-ын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, т гүйцэтгэлийн тайланг хамруулж, горим сорил хэрэгжүүлсний үр дүнд нийт 481,330.0 төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлж, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой 1 залруулж, 374,412.0 мянган төгрөгийн 5 зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, 106,918.0 төгрөгийн 5 зөвлөмж хэрэгжүүлээгүйг аудитын тайланд тусгалаа.

#### 4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12,040.0 мянган төгрөгийн зөрчлийг ар албан шаардлага, 80,099.4 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 64,000.0 төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 17,552.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хэ шатандаа, хэрэгжилт 88.8 хувьтай байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт* /мянган т

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Х |
| Албан шаардлага | 2 | 29,592.0 | 1 | 12,040.0 | |
| Зөвлөмж | 5 | 144,099.4 | 4 | 80,099.4 | |
| **Нийт дүн** | **7** | **173,691.4** | **5** | **92,139.4** | |

Өмнөх оны аудитаар өгсөн төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан тушаалтнаар нөхөн төлүүлэх 17,552.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар Гэ хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны 01/370 дугаар албан тоотоор аймаг, ни дүүргийн ГБХЗХГ /хуучин нэрээр/, хэлтэс харьяа байгууллагуудад "Тушаал шийд хэрэгжилтийг хангаж ажиллах тухай" чиглэл хүргүүлснээр төрд учирсан хохирлыг барагдуу Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2023 101/ШШ2023/04396 дугаар захирамжаар Төрийн албаны зөвлөлөөс нэхэмжилсэн 8,137.9 төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

### 4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт НҮБ-ийн Хүүхдийн сан, НҮБ-ийн Хө хөтөлбөрөөс хүүхдийн эрхийг хамгаалах хөгжүүлэх чиглэлээр дэмжлэг, үзвэр, үйлчилгээ, хамгааллын зардал, түр хамгаалах байрны нөхцөл сайжруулах, нөлөөллийн үйл ажи явуулах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх зэрэг хөтөлбөр арга хэмжээний санхүүжи зарцуулалт болон сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлэг арга хэмжээний хүрсэн үр дүн, хэрэгх түүврийн горим сорил хэрэгжүүлсэн хэдий ч цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл б хамрах хүрээнээс шалтгаалан хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй байс Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэлийн аудит оруулах шаардлагатай, мөн ҮАГ-ын 20 253/А0170074 дугээр 17,552.0 мянган төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг дар аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 5,020.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Аудитаар нийт 1,000,125.0 мянган төгрөгийн 15 зөрчил[2] илэрснээс, 500,607.7 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлж, 499,517.3 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 1,000,125.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

### 5.1 Албан шаардлага

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй 94,471.2 мянган төгрөг, онгоцны тийз, ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүй 70,716.7 мянган төгрөг, нийт 165,190.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд байгууллагын нийт 49 албан хаагчаас 41 албан хаагчид 82 удаа 16,954.6 мянган төгрөгийн цалинтай чөлөө олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Байгууллагын албан хаагчдад нийтлэг цалинтай чөлөө олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

3. Албан хаагчдын 2023 оны 3, 4 дүгээр улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшууллыг олгохдоо сарын үндсэн цалингийн 100 хувиар тооцон 14 албан хаагчид 18,883.6 мянган төгрөг, сахилгын шийтгэлтэй ажилтанд 496.7 мянган төгрөг, нийт 19,380.3 мянган төгрөгийн шагнал урамшууллыг олгож, 988.9 мянган төгрөгийг илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна." Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7.Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй. Төрийн

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3.1-д "Сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно." гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг тооцохдоо тогтоосон хувь хэмжээг баримтлалгүй, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

4. ГБХЗХГ-ын /хуучин нэрээр/ даргын 2023 оны А/192 дугаар тушаалаар хүслийн хайрцаг, дугтуй хэвлүүлэхэд 30,000.0 мянган төгрөг, сургалт арга хэмжээний лед дэлгэцийн угсралтад 23,000.0 мянган төгрөг, зураглал зохиох санхүүжилтэд 24,050.0 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгаанд 49,200.0 мянган төгрөг, нийт 126,250.0 мянган төгрөгийн нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээнд шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2023 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/20 дугаар тушаалын 1 дэх хэсэгт "Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хийх ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ байгуулах, үр дүнг дүгнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

5. ГБХЗХГ-ын /хуучин нэрээр/ даргын 2023 оны А/84 дүгээр тушаалаар хүүхдийн зуслангийн удирдлагуудыг чадавхжуулах сургалтад 18,095.0 мянган төгрөг, А/123 дугаар тушаалаар ажлын байрны стресс менежментийн дотоод сургалтад 6,288.0 мянган төгрөг, нийт 24,383.3 мянган төгрөгийг зарцуулж, үр ашиггүй, тэвчиж болох зардал зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж сургалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ зохион байгуулахад нийт 62,439.4 мянган төгрөгийн томилолтын зардал зарцуулсан, ажлын тайлан анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

7. Өмнөх аудитаар өгөгдсөн агентлагийн орон тооны дээд хязгаарт багтаагүй байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт батлагдаагүй даргын туслах, ...

бодогч, касс, эд аж ахуйн нярав, жолооч, үйлчлэгч зэрэг орон тоонд 7 хүнийг гэрээгээр ажиллуулж 85,020.6 мянган төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гаргаж, зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, Засгийн газрын тогтоолоор баталсан бүтэц, орон хязгаарыг мөрдөж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

8. Тус газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан тайлан ирүүлэх цаглабарт хугацаанаас 6 хоног хоцроож ирүүлсэн, аудит хийх явцад саад учруулан аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудалд хариу тайлбар хуулийн хугацаанд ирүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;", Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчаас тайлбар гаргуулах, тодорхой асуулт тавьж, хариулт авах;", 16 дугаар зүйлийн 16.1.3-т "төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, аудитын Төрийн аудитын тухай хуулийг зөрчсөн буруутай албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

*1.1 <u>Илрүүлэлт</u>:* Сургалт, хэлэлцүүлэг арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах гарын авлага, тараах материал, бэлэг зэрэг 97,098.0 мянган төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулан бүртгэлгүй, зардалд шууд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д "эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахгүй байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
*1.2 <u>Өгсөн зөвлөмж</u>:* Бараа материалын хөдөлгөөнийг нэг бүрийн үнэ, төрөл зүйлээр ангилан бүртгэж, тайлагнах.

*2.1 <u>Илрүүлэлт</u>:* Бараа материалын дансанд тайлант оны эцэст нөөцлөх шаардлагагүй 8,466.8 мянган төгрөгийн түлш, шатахууны зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*2.2 <u>Өгсөн зөвлөмж</u>:* Нөөцлөх шаардлагагүй бараа материалыг бэлтгэж, нөөцлөхгүй байх.

## 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

*3.1 <u>Илрүүлэлт:</u>* Үндсэн хөрөнгийн дансанд лицензийн хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй 282,708.0 мянган төгрөгийн нийгмийн ажилтны мэдээллийн сан буюу НАМС программ хангамж бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах", 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*3.2 <u>Өгсөн зөвлөмж</u>*: Ашиглагдахгүй байгаа программ хангамжийг данс бүртгэлээс хасах.

## 3. Цалингийн данстай холбоотой

*4.1 <u>Илрүүлэлт:</u>* Агентлагийн батлагдсан бүтцийн нэгжид байхгүй Сургалт, судалгаа мэдээллийн төв нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/164 дүгээр тушаалын хүрээнд байгуулсан биеэ даасан төрийн үйлчилгээний төсвийн байгууллага боловч төсөв захиран зарцуулах эрхгүй, ХГБХХЕГ-ын нэгж хэлбэрээр үйл ажиллагаа явуулж 8 албан хаагчийн цалин, урамшуулалд нийт 111,244.5 мянган төгрөгийг байгууллагын үндсэн цалингийн зардлаас зарцуулж, зардлын ангилал зөрчин төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна.", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д "хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах", Засгийн газрын баталсан 2017 оны "Хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 231 дүгээр тогтоолын 1-т ... "Сургалт, судалгаа мэдээллийн төв"-ийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус тус байгуулсугай." гэж заасантай нийцэхгүй байна.

*4.2 <u>Өгсөн зөвлөмж</u>*: Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан ажиллах, Сургалт, судалгаа мэдээллийн төв төрийн үйлчилгээний байгууллагын бие даасан байдлыг хангуулахаар арга хэмжээ авч ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

## 4. Дотоод аудит, дотоод хяналттай холбоотой асуудал

*5.1 <u>Илрүүлэлт:</u>* Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөнд 6 гүйцэтгэл, нийцлийн аудит хийхээр төлөвлөснөөс 1 нийцлийн аудит буюу шилэн дансны үйл ажиллагаанд аудит хийж, санхүүгийн болон гүйцэтгэлийн 5 аудитыг хийж гүйцэтгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ:", 7 дугаар зүйлд "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

*5.2 <u>Өгсөн зөвлөмж</u>*: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа дахь эрсдэлийг оновчтой тодорхойлж, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөө боловсруулж, батлуулах хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## . АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл* — */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| ХГБХХЕГ | Ахмадын сангийн үлдэгдэл 5,020.7 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэж, бусад төсөл нөөцийн үлдэгдлээр тайлагнасан байна. | 1 | 5,020.7 | | | | | 1 | 5,020.7 | | | | |
| **Дүн** | | **1** | **5,020.7** | **-** | **-** | **0** | **-** | **1** | **5,020.7** | **0** | **-** | **0** | **-** |

*.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* — */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| ХГБХХЕГ | Тайлант онд байгууллагын нийт 46 албан хаагчаас 41 албан хаагчид 82 удаа 16,954.6 мянган төгрөгийн цалинтай чөлөө олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. | 1 | 16,954.6 | | | 1 | 16,954.6 | | | | | | |
| | Албан хаагчдын 2023 оны 3,4 дүгээр улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшууллыг олгохдоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг зөрчин сарын үндсэн цалингийн 100 хувиар тооцон 14 албан хаагчид 18,883.6 мянган төгрөг, сахилгын шийтгэлтэй ажилтанд 496.7 мянган төгрөг, нийт 19,380.3 мянган төгрөгийн шагнал урамшууллыг олгож, 988.9 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 20,369.2 | | | 1 | 20,369.2 | | | | | | |
| | Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй 94,471.2 мянган төгрөг, онгоцны тийз, ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүй | 1 | 165,190.8 | | | 1 | 165,190.8 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 70,716.7 мянган төгрөг, нийт 165,190.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна. | | | | | | | | | | | | |
| | ГБХЗХГ-ын /хуучин нэрээр/ даргын 2023 оны А/192 дугаар тушаалаар хүслийн хайрцаг, дугтуй хэвлүүлэхэд 30,000.0 мянган төгрөг, сургалт арга хэмжээний лед дэлгэцийн угсралтад 23,000.0 мянган төгрөг, зураглал зохиох санхүүжилтэд 24,050.0 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгаанд 49,200.0 мянган төгрөг, нийт 126,250.0 мянган төгрөгийн нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээнд шууд худалдан авалт хийсэн. | 1 | 126,250.0 | | | 1 | 126,250.0 | | | | | | |
| | ГБХЗХГ-ын /хуучин нэрээр/ даргын 2023 оны А/84 дүгээр тушаалаар хүүхдийн зуслангийн удирдлагуудыг чадавхжуулах сургалтад 18,095.0 мянган төгрөг, А/123 дугаар тушаалаар ажлын байрны стресс менежментийн дотоод сургалтад 6,288.0 мянган төгрөг, нийт 24,383.3 мянган төгрөгийг зарцуулж, үр ашиггүй, тэвчиж болох зардал зарцуулсан байна. | 1 | 24,383.0 | | | 1 | 24,383.0 | | | | | | |
| | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж сургалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ зохион байгуулахад нийт 62,439.4 мянган төгрөгийн томилолтын зардал зарцуулсан, ажлын тайлан анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. | 1 | 62,439.4 | | | 1 | 62,439.4 | | | | | | |
| | Өмнөх аудитаар өгөгдсөн агентлагийн орон тооны дээд хязгаарт багтаагүй байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт батлагдаагүй даргын туслах, тооцооны нягтлан бодогч, касс, эд аж ахуйн нярав, жолооч, үйлчлэгч зэрэг орон тоонд 7 хүнийг гэрээгээр ажиллуулж 85,020.6 мянган төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гаргаж, зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 1 | 85,020.6 | | | 1 | 85,020.6 | | | | | | |
| | Тус газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн | 1 | | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хуульд заасан тайлан ирүүлэх цаглаварт хугацаанаас 6 хоног хоцроож тайлан ирүүлсэн байна. | | | | | | | | | | | | |
| | Сургалт, хэлэлцүүлэг арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах гарын авлага, тараах материал, бэлэг зэрэг 97,098.0 мянган төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулан бүртгэлгүй, зардалд шууд бүртгэсэн байна. | 1 | 97,098.0 | | | | | | | 1 | 97,098.0 | | |
| | Бараа материалын дансанд тайлант оны эцэст нөөцлөх шаардлагагүй 8,466.8 мянган төгрөгийн түлш, шатахууны зарцуулагдаагүй үлдэгдэл байна. | 1 | 8,466.8 | | | | | | | 1 | 8,466.8 | | |
| | Үндсэн хөрөнгийн дансанд лицензийн хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй 282,708.00 мянган төгрөгийн НАМС /нийгмийн ажилтны мэдээллийн сан буюу www.nas.fcy.gov.mn/ программ хангамж бүртгэлтэй байна. | 1 | 282,708.0 | | | | | | | 1 | 282,708.0 | | |
| | Агентлагийн батлагдсан бүтцийн нэгжид байхгүй Сургалт, судалгаа мэдээллийн төв нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/164 дүгээр тушаалын хүрээнд байгуулсан биеэ даасан төрийн үйлчилгээний төсвийн байгууллага боловч төсөв захиран зарцуулах эрхгүй, ХГБХХЕГ-ын нэгж хэлбэрээр үйл ажиллагаа явуулж нийт 8 албан хаагчийн цалин, урамшууналд нийт 111,244.5 мянган төгрөгийг байгууллагын үндсэн цалингийн зардлаас зарцуулж, зардлын ангилал зөрчин төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байна. | 1 | 111,244.5 | | | | | | | 1 | 111,244.5 | | |
| | **Дүн** | **12** | **1,000,125.0** | **0** | **-** | **7** | **500,607.7** | **1** | **-** | **4** | **499,517.3** | **0** | **-** |

*6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал*

*/мянган төгрөгөөр/*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үнэлгээ: Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| ХГБХХЕГ | Тус газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан тайлан ирүүлэх цаглаварт хугацаанаас 6 хоног хоцроож тайлан ирүүлсэн байна. | 1 | - | | | 1 | - | | |
| | Шилэн дансны цахим хуудсанд нийт 171 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, байршуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - |
| | Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөнд 6 гүйцэтгэл, нийцлийн аудит хийхээр төлөвлөснөөс 1 нийцлийн аудит буюу шилэн дансны үйл ажиллагаанд аудит хийж, санхүүгийн болон гүйцэтгэлийн 5 аудитыг хийж гүйцэтгээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | | **3** | **-** | **0** | **-** | **1** | **-** | **2** | **-** |